



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 04206

Чингис хот

Сэргээн босгох арга хэмжээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.10, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдөр аадар бороо орж тус аймгийн Хэрлэн сумын хэмжээнд үерийн эрсдэл үүссэнтэй холбогдуулан хамгаалах ажилд шаардлагатай 21256900 /хорин нэгэн сая хоёр зуун тавин зургаан мянга есөн зуун/ төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргасугай.

2. Үер усны аюулгаас хамгаалах, сэргээн босгох ажлын төсвийн задаргааг нэгдүгээр хавсралтаар, улсын онцгой комиссоос шийдвэрлэсэн бохирын ус соруулах тусгай зориулалтын 6 тээврийн хэрэгслийн шатахууны зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үерийн аюул болон сэргээн босгох үед ажиллах бүлгийн бэлтгэл, бэлэн байдал, ажиллах хүн хүчийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

Зардлын тооцоо

| № | Үйл ажиллагааны төрөл | Зардлын нэр төрөл | | | | | | Дүн |
|---|---|-------------------|---------|-----------|-------------|----------------------------|------------------------------|------------|
| | | Шатахуун | Сэлбэг | Хоол | Холбоо багц | Материалын зардал /шуудай/ | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | |
| 1 | Хэнтий ОБГазраас ажиллаж байгаа 90 алба хаагч | | | 4,050,000 | 1,000,000 | 500,000 | 1,600,000 | 7,150,000 |
| 2 | ОБЕГ-аас ажиллаж байгаа 20 алба хаагч | | | 900,000 | | | | 900,000 |
| 3 | Бэрх, Борөндөр-с ажиллаж байгаа 90 алба хаагч | | | 1,800,000 | | | | 1,800,000 |
| 4 | Онцгой комисс /бичиггийн боомт, ариутгалын материал татан авах/ | 306,900 | | | | | | 306,900 |
| 5 | Хэнтий ОБГазраас ажиллаж байгаа 14 автомашин, 7 мотопомп | 2,120,000 | 500,000 | | | | | 2,620,000 |
| 6 | ОБЕГ-аас ажиллаж байгаа 2 автомашин 160л ² | 480,000 | | | | | | 480,000 |
| 7 | 4 ковш ажиллах шатахуун 3.0 сая төгрөг, 500.0 төгрөг элс зөөх | 5,500,000 | | | | | | 5,500,000 |
| | Дүн | 8,406,900 | 500,000 | 6,750,000 | 1,000,000 | 500,000 | 1,600,000 | 18,756,900 |

Аймгийн Засаг даргын 2020 оны
06 дугаар сарын 25 өдрийн А/296
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Зардлын тооцоо

| Д/д | Тээврийн хэрэгслийн төрөл | Тоо ширхэг | Шатахууны төрөл | | | Нийт |
|-----|---------------------------|------------|-----------------|------|-------|---------|
| | | | А-80 | А-92 | ДТ | |
| 1 | Бохирын ус сорогч машин | 3 | | | 660 л | 1351750 |
| 2 | Пургон | 1 | | 70 л | | 105000 |
| 3 | ДУК ариутгалын машин | 1 | | | 165 л | 338250 |
| 4 | Урал машин | 1 | 470 л | | | 705000 |
| | Бүгд | 6 | | | | 2500000 |